

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/21 дүгээр зүйлийн 21.2.6 дахь заалт:

“21.2.6.энэ хуулийн 21.2.5-д заасныг үл харгалзан Монгол Улсад байрладаг аж ахуйн нэгжийн хувьцаа, хувь оролцооны 50 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчид олгосон тухайн хувьцааны ногдол ашгийн орлогын дүнд 15 хувиар.”

2/25 дугаар зүйлийн 25.9, 25.10 дахь хэсэг:

“25.9.Энэ хуулийн 25.1.3-т заасан орлогод бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлнэ.”

“25.10.Суутган төлөгч албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын сүүлийн өдөр, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын сүүлийн өдөр өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.”

2 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “14, ” гэсний дараа “15, ” гэж, 25 дугаар зүйлийн гарчгийн “төлөх” гэсний дараа “, тайлагнах” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/23 дугаар зүйлийн 23.1, 23.3, 23.4 дэх хэсэг:

“23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 15, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон 9,600,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувиар хөнгөлнө.”

“23.3.Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар орон сууц худалдан авах, барих, орон сууцны нөхцөл сайжруулахад зарцуулсан төлбөрийн баримтаар нотлогдох

дараах зардалтай тэнцэх хэмжээний албан татварын хөнгөлөлтийг эдлүүлэх бөгөөд хөнгөлөлтийн дүн заалт тус бүр 15 сая төгрөг хүртэл байна.

23.3.1.эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын стандарт хангасан орон сууц худалдан авах, барихад зарцуулсан хөрөнгө;

23.3.2.гэр хорооллын орон сууцны дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлт бий болгох нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур, дулааны насос худалдан авсан зардал;

23.3.3.аймаг сум, дагуул хот, Нийслэлийн дагуул хот, Багануур, Багахангай, Налайх дүүрэг, дэд төвийн хилийн цэсийн дотор анх удаа орон сууц худалдан авах, барихад зарцуулсан хөрөнгө.”

“23.4.Энэ хуулийн 23.3-т заасан тухайн татварын жилд мөрдөх хөнгөлөлт тус бүрийн хэмжээг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, хотын Зөвлөл тогтооно.”

2/26 дугаар зүйл:

“26 дугаар зүйл.Тайланг цахимаар урьдчилан боловсруулах үйлчилгээ, татвар төлөгчийн төлөх, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах

26.1.Татвар төлөгчийн албан татварыг тодорхойлох, ногдуулах, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах, үүсэж болзошгүй татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор татварын бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн татварын албанаас тайлангийн төслийг урьдчилан боловсруулж, цахим татварын системээр татвар төлөгчид хүргүүлэх үйлчилгээ үзүүлнэ.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан тайлангийн төсөлд татвар төлөгчийн татвар ногдох орлого, чөлөөлөх орлого, хасагдах зардал, татвар ногдуулах орлого, ногдуулсан, суутгуулсан, төлсөн болон төлбөл зохих албан татвар, буцаан авах боломжтой татварын хөнгөлөлтийг цахим татварын системээр тооцож, тусгана.

26.3.Энэ хуулийн 26.1-д заасан тайлангийн төслийг татварын албанаас дор дурдсан хугацаанд цахимаар хүргүүлнэ:

26.3.1.албан татвар төлөгч хүсэлт хүргүүлсэн бол хүсэлт хүргүүлсэн өдрийн өмнөх сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон тухай бүр;

26.3.2.улирлын тайлангийн төслийг дараагийн улиралд;

26.3.3.жилийн эцсийн тайлангийн төслийг дараа оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

26.4.Албан татвар төлөгч энэ хуулийн 26.3-т заасны дагуу татварын албанаас хүргүүлсэн тайланд нэмэлт мэдээлэл тусгах, татвар ногдох орлогоос хасагдах зардал, төлбөл зохих татварын мэдээллийг нэмж тайлагнах шаардлагатай гэж үзвэл тайлангаа залруулж болно.

26.5.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч татварын жилд гадаад улсад олсон орлого, төлбөл зохих татварын мэдээллийг энэ хуулийн 26.3.3-т заасан жилийн эцсийн тайланд тусгана.

26.6.Албан татвар төлөгч тухайн жилийн тайлангийн төслийг дараа оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор хянан баталгаажуулах ба хянан баталгаажуулснаар татварын тайлан тушаасанд тооцно.

26.7.Татвар төлөгч энэ хуулийн 26.6-д заасан хугацаанд тайлангийн төслийг хянаж баталгаажуулаагүй бол татварын хөнгөлөлтийг хасаж тухайн тайланд туссаны дагуу эцсийн төлбөл зохих татварыг тооцно.

26.8.Татварын нэхэмжлэхийг татвар төлөгч хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд энэ хуулийн 26.4-т заасны дагуу тайлангаа залруулж тайлагнана.

26.9.Албан татвар төлөгч нь төлбөл зохих албан татвараа дараа оны 3 дугаар улиралд багтаан төсөвт төлнө.”

3/28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг:

“28.4.Энэ хуулийн 28.3-т заасан албан татвар төлөгчийн буцаан авах, илүү төлсөн албан татварыг тухайн татварын албаны харьяалагдах засаг захиргааны нэгжийн төрийн сангийн дансаар дамжуулан дараах хугацаанд буцаан олгоно:

28.4.1.энэ хуулийн 28.1.2-т заасан буцаан олголтыг татвар төлөгчид ажлын 15 хоногт буцаан олгох;

28.4.2.энэ хуулийн 28.1.2-т зааснаас бусад буцаан олголтыг дараа оны 2 дугаар улиралд багтаан олгох.”

4 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь заалтын “урамшууллын” гэснийг “хөнгөлөлтийн” гэж, 23 дугаар зүйлийн 23.11 дэх хэсгийн “23.7” гэснийг “23.3.2” гэж, 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалтын “17.1.1-д” гэснийг “12.1.3-т”, “21.2.1-д” гэснийг “21.4-т” гэж, 25.7 дахь хэсгийн “татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг” гэснийг “татварыг” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтын “эхэлж эдлэх” гэснийг “улирал, жилээр” гэж, 28.1.3 дахь заалтын “албан татвар төлөгч энэ хуулийн 28.1.1-д заасан хязгаарт багтаан өөрөө сонгож эдлэх” гэснийг “жилээр” гэж, 28.1.4 дэх заалтын “хуульд заасан” гэснийг “хуулийн 23.1-д зааснаас бусад” гэж, 28.1.5 дахь заалтын “23.4-т” гэснийг “23.3-т” гэж, 28.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 28.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн” гэснийг “Албан татвар төлөгчийн баталгаажуулсан тайлангаар” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.4 дэх заалтын “15.1,” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “21.3,” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.12 дахь хэсгийн “21.3,” гэснийг, 23.14 дахь хэсгийн “23.1,” гэснийг, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн “, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт

тэмдэглэж,” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “энэ хуулийн 27.1, 27.2, 27.4, 27.5, 27.6-д заасны дагуу хүргүүлсэн” гэснийг, 28.5 дугаар хэсгийн “Энэ хуулийн 28.4-т заасан” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6, 15.7, 15.8 дахь хэсгийг, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийг, 23 дугаар зүйлийн 23.7, 23.10, 23.13 дахь хэсгийг, 25 дугаар зүйлийн 25.5 дахь заалтыг, 27 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг